



# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2022/262/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2-10
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3-4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6-7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7-8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12-13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12-13
4. Аудитын илрүүлэлт .....	12-13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
АЛБАНЫ ДАРГА С.МӨНХБААТАР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>Төгрөгөөр</i>			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,702,443.00</b>	<b>5,494,387.60</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	4,702,443.00	5,494,387.60
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,144,330.00	1,252,930.00
35130	Эм боох материал	1,144,330.00	1,252,930.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	3,558,113.00	4,241,457.60
35420	Аж ахуйн материал	3,249,620.00	3,941,520.00
35440	Түлш, шатах тослох материал	308,493.00	299,937.60
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>166,607,370.64</b>	<b>154,099,151.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	166,607,370.64	154,099,151.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	54,607,370.64	42,099,151.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44,700,000.00	44,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,166,666.78	-18,616,666.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,130,760.00	35,130,760.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17,779,685.46	-23,480,372.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,743,310.28	10,338,630.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,020,347.40	-5,973,200.32
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	112,000,000.00	112,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	112,000,000.00	112,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>171,309,813.64</b>	<b>159,593,538.60</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>171,309,813.64</b>	<b>159,593,538.60</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	171,309,813.64	159,593,538.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	115,485,200.00	115,485,200.00
51101	Өмч: - төрийн	115,485,200.00	115,485,200.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	55,824,613.64	44,108,338.60
51210	Өмнөх үеийн үр дүн	55,824,613.64	55,824,613.64
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-11,716,275.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>171,309,813.64</b>	<b>159,593,538.60</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

<i>Төгрөгөөр</i>			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>217,578,687.19</b>	<b>221,765,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,698,487.19</b>	<b>3,920,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,698,487.19	3,920,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,698,487.19	3,920,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,078,500.00	3,920,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,619,987.19	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>198,880,200.00</b>	<b>217,845,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	190,880,200.00	212,372,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	190,880,200.00	212,372,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,000,000.00	5,473,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,473,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>203,352,107.00</b>	<b>233,481,775.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>203,352,107.00</b>	<b>233,481,775.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	203,064,983.48	232,561,275.04
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	170,584,587.48	186,668,500.00

210101	Үндсэн цалин	170,584,587.48	186,668,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>3,411,689.00</b>	<b>4,363,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	00.00	850,613.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	94,472.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	75,565.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	18,895.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,411,689.00	3,323,955.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,050,000.00</b>	<b>2,565,000.00</b>
210304	Байрны түрээс	1,050,000.00	2,565,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,075,569.50</b>	<b>11,224,735.40</b>
210401	Бичиг хэрэг	1,526,850.00	1,865,780.00
210402	Тээвэр, шатахуун	5,945,139.50	5,908,555.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	931,900.00	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	671,680.00	2,550,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,984,550.00</b>	<b>2,791,400.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,984,550.00	2,791,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>612,560.00</b>	<b>1,999,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	316,650.00	450,000.00
210604	Урсгал засвар	295,910.00	1,549,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,132,600.00</b>	<b>4,154,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,132,600.00	4,154,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,259,990.00</b>	<b>4,691,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	854,990.00	4,221,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	85,000.00	97,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	252,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,953,437.50</b>	<b>14,103,539.64</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,953,437.50	14,103,539.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>287,123.52</b>	<b>920,500.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>287,123.52</b>	<b>920,500.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	287,123.52	920,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>14,226,580.19</b>	<b>-11,716,275.04</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>14,226,580.19</b>	<b>-11,716,275.04</b>



### **2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*Төгрөгөөр*

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>206,958,700.00</u></b>	<b><u>221,765,500.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,078,500.00</b>	<b>3,920,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	8,078,500.00	3,920,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	8,078,500.00	3,920,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,078,500.00	3,920,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>198,880,200.00</b>	<b>217,845,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	190,880,200.00	212,372,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	190,880,200.00	212,372,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,000,000.00	5,473,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,473,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>193,958,700.00</u></b>	<b><u>220,170,180.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>193,958,700.00</b>	<b>220,170,180.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>193,671,576.48</b>	<b>219,249,680.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	170,560,500.00	186,668,500.00
210101	Үндсэн цалин	91,495,415.00	119,334,292.00
210102	Нэмэгдэл	65,568,591.12	57,388,632.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,496,493.88	9,945,575.28
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,435,776.48	4,363,500.00
210201	Тэтгэврийн даатгал	86,513.04	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,349,263.44	4,363,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,050,000.00	2,565,000.00
210304	Байрны түрээс	1,050,000.00	2,565,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,286,000.00	11,474,280.00
210401	Бичиг хэрэг	1,482,400.00	1,864,480.00
210402	Тээвэр, шатахуун	5,930,200.00	5,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	867,100.00	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,006,300.00	2,809,800.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	2,900,300.00	2,900,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,900,300.00	2,900,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	902,700.00	1,999,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	444,700.00	450,000.00
210604	Урсгал засвар	458,000.00	1,549,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,132,600.00	4,154,000.00
210702	Дотоод албан томилолт	4,132,600.00	4,154,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,403,700.00	5,125,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	998,700.00	4,655,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	85,000.00	97,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	252,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>287,123.52</b>	<b>920,500.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	287,123.52	920,500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	287,123.52	920,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>13,000,000.00</u></b>	<b><u>1,595,320.00</u></b>

5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>13,000,000.00</b>	<b>1,595,320.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,000,000.00</b>	<b>1,595,320.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	13,000,000.00	1,595,320.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,000,000.00	1,595,320.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-13,000,000.00</b>	<b>-1,595,320.00</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	215,372,000.00	215,372,000.00	0.00	100
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	215,372,000.00	215,372,000.00	0.00	100
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	215,372,000.00	215,372,000.00	0.00	100
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	186,668,500.00	186,668,500.00	0.00	100
210101	Үндсэн цалин	113,873,600.00	119,334,292.00	5,460,692.00	104.8
210102	Нэмэгдэл	56,258,900.00	57,388,632.72	1,129,732.72	102.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,536,000.00	9,945,575.28	6,590,424.72	60.1
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,363,500.00	4,363,500.00	0.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	4,363,500.00	4,363,500.00	0.00	100
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,565,000.00	2,565,000.00	0.00	100
210304	Байрны түрээс	2,565,000.00	2,565,000.00	0.00	100
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,720,000.00	10,720,000.00	0.00	100
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	5,900,000.00	5,900,000.00	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	900,000.00	0.00	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,420,000.00	2,420,000.00	0.00	100
2105	<b>Норматив зардал</b>	2,900,000.00	2,900,000.00	0.00	100
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,900,000.00	2,900,000.00	0.00	100
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	450,000.00	450,000.00	0.00	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	450,000.00	450,000.00	0.00	100
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	3,500,000.00	3,500,000.00	0.00	100
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	3,500,000.00	0.00	100
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,</b>	4,205,000.00	4,205,000.00	0.00	100

	<b>үйлчилгээний төлбөр, хураамж</b>				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,735,000.00	3,735,000.00	0.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	97,200.00	97,200.00	0.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	100,000.00	0.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	20,000.00	0.00	100
210807	Газрын төлбөр	252,800.00	252,800.00	0.00	100
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	215,372,000.00	215,372,000.00	0.00	100
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	212,372,000.00	212,372,000.00	0.00	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	212,372,000.00	212,372,000.00	0.00	100
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	3,000,000.00	3,000,000.00	0.00	100
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,000,000.00	0.00	100
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	12.00	12.00	0.00	100
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	0.00	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төгрөгөөр Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>5,473,000.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>5,473,000.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		5,473,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		754,280.00
Бичиг хэрэг		364,480.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		389,800.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		3,144,320.00
Тавилга		1,595,320.00
Урсгал засвар		1,549,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>		654,000.00
Дотоод албан томилолт		654,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		920,400.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		920,400.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		5473000.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		5,473,000.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,473,000.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албатай төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 13Т/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын үйл ажиллагааг шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн боловсронгуй орчин, оновчтой зохион байгуулалт, баталгаатай арга зүй, техник-технологийн дэвшлийг бүрэн ашиглах нөхцөлийг бий болгон, хүний нөөцийн чадварлаг баг бүрдүүлснээр аливаа хэргийг шинжлэх ухаанч нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад тайлант онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 203.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4,067.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Тайлант онд байгууллагаас авах авлага 0.7 сая төгрөгөөр, богино хугацаат өр төлбөр 10.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 4.7 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 5.5 сая төгрөг болж 0.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн материал болон эм боох материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй болбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 166.6 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 154.1 сая төгрөг болж буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Мөнгөн хөрөнгийн тухайд нийт орлого өмнөх онд 207.0 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 221.8 сая төгрөг болж 14.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь байгууллагын бүтэц орон тоог 1-ээр нэмэгдсэнтэй холбоотой цалингийн сан нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тус байгууллагын санхүүгийн тайлангийн тодруулгад тайлант онд үүссэн өр, авлага, үндсэн хөрөнгө, бараа материал болон мөнгөн хөрөнгө, төсвийн гүйцэтгэлийн талаарх бүхий л мэдээллийг бүрэн тусгасан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2021 оны төсвийн төслийг 206.9 сая төгрөгөөр төлөвлөн боловсруулж төсвийн саналаа 2020 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 13Т/137 тоот албан бичгээр Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн санхүү төлөвлөлт хангамжийн газарт хүргүүлсэн байна. Хүргүүлсэн төсвийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн санхүү төлөвлөлт хангамжийн газар хянаж үзээд 215.3 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 215.3 сая төгрөгийн төсөв баталснаас 212.4 сая төгрөгийг улсын төсвөөс 3.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 212.4 сая төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 3.9 сая төгрөг, нийт 216.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 215.4 сая төгрөгийг зарцуулж 0.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Бараа үйлчилгээний зардалд 215.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс шуурхай байдлыг дэмжихэд дэмжлэг үзүүлж 1.0 сая төгрөгийг, Үндсэн үйл ажиллагааны орлогоос давсан орлого 4.5 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд тус тус хуваарилсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас бараа үйлчилгээний зардалд 5.5 сая зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар асуудлыг онцолсон хэсэг байхгүй болно.

#### Бусад асуудлын тухайд

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага:

- Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
- Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.
- Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

### 3.8 Аудитын гол асуудал

1. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас нийт 1.4 сая төгрөгийн бараа материалыг эдийн засгийн ангилал зөрчиж худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлагдсан журмын 2 дугаар хавсралттай нийцэхгүй байна.

2.Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 1.7 сая төгрөгийн бараа материалыг бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлагдсан журмын 2 дугаар хавсралттай нийцэхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 3 мэдээлэл байгаа бөгөөд өөр алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын анхан шатны баримт материал, гэрээнүүдийг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул ямар нэгэн зөвлөмжийг өгөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 3.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 3.1 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгсөн.

### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 1.4 сая төгрөгийн, бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас 1.7 сая төгрөгийн бараа материалыг тус тус эдийн засгийн ангилал зөрчиж бэлтгэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлагдсан журмын 2 дугаар хавсралттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж Засгийн газрын 2021 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний алба	1	3.1							1	3.1



## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						<i>Төгрөгөөр</i>
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>115,485,200.00</b>	<b>00.00</b>	<b>55,824,613.64</b>	<b>00.00</b>	<b>171,309,813.64</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>115,485,200.00</b>	<b>00.00</b>	<b>55,824,613.64</b>	<b>00.00</b>	<b>171,309,813.64</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>115,485,200.00</b>	<b>00.00</b>	<b>55,824,613.64</b>	<b>00.00</b>	<b>171,309,813.64</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,716,275.04	00.00	-11,716,275.04
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>115,485,200.00</b>	<b>00.00</b>	<b>44,108,338.60</b>	<b>00.00</b>	<b>159,593,538.60</b>